

гадаад салбар, гадаад бодлогын түүх ба олон улсын харилцаа буюу түүхийн шинжлэх ухааны гадаад үргэлжлэл, олон улсын эдийн засгийн харилцаа буюу эдийн засгийн шинжлэх ухааны гадаад үргэлжлэл мөн. Эдгээр тусгай судлалууд дээр Өрнө дахинд улс төрийн шинжлэх ухаан ба улс төр судлалын гадаад хэсэг буюу олон улсын бодлогогүйг хөгжүүлж байна” хэмээн албан ёсоор чиглэлээ товлож, улс төрийн шинжлэх ухааныг хөгжүүлэхийн чухлыг тодорхойлсон. Ингэж онолын сэтгэлгээгээ цэгцэлж авсан нь ЗХУ ба өдгөө ОХУ-д улс төрийн шинжлэх ухаан өрнөдийн жишгээр хөгжиж эхлэх боломжийг нээж өгсөн гэж хэлж болно.

Гэтэл Монголын судлаачид эрин үеийн шаардлагыг эс анхааран хөгжил дэвшлийн үйл явцаас хөндий сүүл барьсаар бахь байдгаараа байсаар байгаа нь харамсалтай. Тиймээс өөрсдийгөө улс төр судлаачид гэж үздэг эрдэмтдийг цуглуулан, эрдэм шинжилгээний чуулга уулзалт зохиож, онолын түвшинд санал солилцуулан, үзэл бодлоо шинжлэх ухааны үүднээс цэгцэлж дэлхий дахины улс төр судлал, улс төрийн шинжлэх ухааны хөгжлийн явцад нэгдэн орох ёстой болгоод байна.

## Олон Улсын Харилцааны Дээд Сургууль

АЛТАН АРГАМЖ

### АЛТАН АРГАМЖ

VOL.3

1/2000

## “МОНГОЛ ХЯТАДЫН ХАРИЛЦААНЫ ОНЦЛОГ”

МУИС, ОУХС-ийн

проф. Ж.Баясах

### Удиртгал

Монгол Хятад хоёр улс хаая дэрлэн 2000 жилийн тэртээ түүхийг туулан өнөрүүлсэн. Тэртээ 2000 жилийн өмнө Монголын Хүннү улс Хятадын Хань улс хоёрын хооронд анхны гэрээ байгуулагдаж Цагаан хэрмээс араар нутаглагч “морьтон ард түмэн” шаньюийн иргэд, Цагаан хэрмийн өмнө зүгээр нутаглагсад “тариа хагалагч ард түмэн” бол Хань улсын иргэд. Үүнээс хойш “морьтон ард түмэн”, “тариа хагалагч ард түмэн” мөр зэрэгцэн эрх эдлэнэ гэсэн нь улгаа хоёр улс их, бага, өндөр, нам гэлгүйгээр тэгш эрх эдлэнэ гэсэн гэрээ юм. XIII зуунд Монгол туургатан хүчирхэгжиж ирэхийн хамтаар феодалын бутраллыг эцэслэж Монгол үндэстэн бий болж өөрийн төр улсаа эзэнт гүрний хэлбэрээр дахин мандуулахад аль Сүй Тан улсаас хойш Өмнөд Умардаараа задарсан Хятад орны эхлээд Умард зүгт оршиж байсан Зөрчидийн Алтан улс, Тангадын баруун Ся улс Монголын эзэнт улсад дагаар орж улмаар XIII зууны II хагаст өмнө зүг оршиж байсан Өмнөд Сүн улс Монголд эзлэгдсэнээр Монгол, Хятадын түүхнээ Их Юань улс байгуулагдаж зөвхөн Монгол, Хятад төдийгүй Солонгос болон өмнө зүгийн улсуудыг ноёрхсон билээ. Их Юань улс мөхсөний дараа Монгол улсад Манжид дагаар ортол Умард Юань улс оршин тогтнож байлаа. Энэ улсыг манай түрүү үеийн түүхчид онцгойлон нэрийдэж байгаагүй бөгөөд энэ үеийг феодалын бутраллын үе гэдгээр ерөнхийлөн тодорхойлж байлаа.

1644 онд умард зүгийн нүүдэлчин Манж угсааныхан Монголчуудын дэмжлэгээр Хятад орныг бүхэлд нь эзэлж 1911 он хүртэл өөрийн ноёрхлыг тогтоосон билээ. Монголчууд 1631 онд Өвөрлөгчид, 1691 онд Ар халх, ХVII зууны дунд үед Зүүн гар улсыг эзэлж авсанаар даяар монголчууд манжийн дарангуйлалд орж 1911 онд өөрийн тусгаар тогтнолыг сэртээж, 1921 онд ардын ардчилсан хувьсгал гарсанаар улмаар 1924 онд БНМАУ-ыг байгуулсан. Тэгвэл Хятад орон 1911 оноос өөрийн тусгаар тогтнолыг мөн тунхаглан зарлаж 1949 он хүртэл хөрөнгөтний замаар явж 1949 онд ардын засгийг тогтоож БНХАУ-ыг байгуулж одоо нэгэнтээ 50 жилийн нүүр үзлээ.

### **БНМАУ, БНХАУ-ын хоёр талын харилцаа**

1924-1990 онд Монгол улс нь өөрийнхөө Үндсэн хуулиар БНМАУ хэмээн нэрлэгдэж байсан бөгөөд эл хугацаанд социализм байгуулах нь үндсэн хөгжлийн зорилт нь болж байлаа. Тэгвэл 1949 оноос 1999 он хүртэлх хугацаанд БНХАУ нь социалист бүтээн байгуулалт өрнүүлж сүүлийн 20 жил "Хятадын онцлогтой" социализм байгуулж ирлээ. Өөрөөр хэлбэл эл хугацаанд хоёр улс нь улс төр, үзэл суртлын хувьд марксизм, ленинизмээр тулгуурласан бодлогыг хэрэгжүүлж байсан гэж хэлж болно. Монгол улс нь эл хугацаанд 1949-1962 оны хооронд Хятад улстай найрсаг харилцаатай явж үлдсэн он жилүүд тухайлбал 63 жил нь зөвхөн умард хөрштэйгөө "дэндүү ойртож" нэг талын харилцааг шүтэж ирсэн байх юмаа. Орос улс нь Дэлхийн 2-р дайны төгсгөл хүртэл Монгол улсыг тусгаар улс гэж аль нэг баримт бичигт хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд харин ч 1924 онд ДИУ-тай байгуулсан гэрээндээ "БНМАУ нь ДИУ-ын салшгүй хэсэг" гэж тусгасан байдаг. Зөвхөн 1945 оны ялалтын гэрээнээс хойш Монгол улсыг тусгаар улс хэмээн үзэж ДИУ-аар БНМАУ-ыг хүлээн зөвшөөрүүлэх тал дээр чармайлт гаргаж бүх ард түмний санал асуулга явуулсны дараагаар 1946 оны эхээр ДИУ нь БНМАУ-ыг хүлээн зөвшөөрсөн байна. Ийнхүү Дэлхийн 2-р дайнаар дэлхийн олон улсын харилцаанд шинэ уур амьсгал орж хоёр систем байгуулагдсаны дараагаар Монгол улсыг умард, өмнөд хөршүүд нь хүлээн зөвшөөрчээ. Чухамхүү энэ үеэс л Монгол улс хоёр хөрштэйгөө элчин сайдын хэмжээнд харилцаа тогтоож чадсан байна. 1949

оны 10 сарын 1-нд БНХАУ улс байгуулагдмагц БНМАУ-ын Засгийн газар шинэ тулгар байгуулагдсан шинэ Хятад улсыг хүлээн зөвшөөрч байгаагаа албан ёсоор мэдэгдэхийн хамт ДИУ-тай байгуулсан дипломат харилцаагаа тасалснаа нотолсон. Мөн оны 10 сарын 10-нд БНХАУ-ын Засгийн газар БНМАУ-ын Засгийн газарт баарын цахилгаан утас илгээж БНМАУ-ыг хүлээн зөвшөөрч байгаагаа хариу мэдэгдсэн байна.

1966-1976 онд БНХАУ-д "пролетарийн агуу их соёлын ярьсгал" гарсан он жилүүдэд хоёр улсын харилцаа эрс хурцдаж Монгол улс нь Зөвлөлтийн цэргийг эх орондоо оруулж Монгол, Хятадын хил нь Зөвлөлт, Хятадын зэвсэгт хүчний сөргөлдөх эдийн бүс болж хувирсан юм. "Соёлын хувьсгал"-ын он жилүүдэд БНМАУ-ыг "ревизионистуудын гар хөл", "Зөвлөлтийн мах Бэлтгэлийн анги" зэргээр элдвээр нэр хаяж байсан бөгөөд түрний хамтад Монгол улсыг "хэзээнээс нааш Хятадын салшгүй хэсэг" зөвхөн "Хаант Оросын өдөөн хатгалгаар салан тусгаарлаж "тусгаар тогтнол"-ыг зарлан тунхаглаж эх нутгаасаа салж БНМАУ эцгийг Зөвлөлт Оросын дэмжлэгээр байгуулсан" гэх мэтээр түүх түгээлж байсан. Монгол улс ч гэсэн Зөвлөлтийн нэгэн адилгаар БНХАУ-ыг "буруу замаар будаа тээж байна" хэмээн "их залуурчийн элдэв үзэгдэж Хятадын ард түмэн өлөн ээлмүүн амьдарч байна", "Хятадын эрх баригчид дэлхий аюулгүй байдлад заналхийлж байна" гэх зэргээр буруушааж байсан байх юм.

1985 онд ЗХУ-д М.С.Горбачёв "Өөрчлөн байгуулалт" хийж эхэлснээр Зөвлөлт, Хятадын харилцаанд өөрчлөлт гарч сэйлрэхийн хамтаар Монгол, Хятадын харилцаа ч хэвийн болох голчирал руу орж энэхүү харилцаа ЗХУ задарч Зөвлөлтийн цэрэг Монголоос 1990-1991 онд бүрмөсөн гарснаас хойш улам өсөж дэвжих болсон.

### **"Хүйтэн дайн"-аас хойшхи Монгол, Хятадын харилцаа**

Монголд 1989 оноос ардчилсан хөдөлгөөн гарч идэвхжихийн хамтаар мөн "Хүйтэн дайн"-ы үе дууссанаар Монгол улсад нийгмийн хөгжлийн чиг баримжааг өөрчилж олон намын систем бүрэлдэн тогтож, парламентын засаглал тогтсон үйл явц нь "Хүйтэн дайн"-аас хойшхи үед багтах бөгөөд чухамхүү энэ үеэс

гадаад болдогодоо жинхэнэ бие даасан боллого явуулах болж аливаа улстай харилцах боллогоо "Гадаад боллогын үзэл баримтлал"-аараа тодорхойлж хоёр хөрштэйгөө харилцах явдлыг эн тэргүүнд тавьж хоёрдугаарт хөгжингүй орнууд гуравдугаарт уламжлалт харилцаатай орнууд хэмээн удирдамж болгон ажиглаж байна. Хоёр улсын хооронд найрамдал хамтын ажиллагааны гэрээ 1994 онд шинээр байгуулагдсан нь хоёр улсын харилцааг цаашид хөгжүүлэх эрх зүйн үндэс болсон юм. Өнгөрөгч хугацаанд хоёр улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Их хурлын дарга нар хоёр биендээ харилцан айлчилж дээд хэмжээний уулзалтууд тогтмолжиж байхад ард иргэд хоёр биендээ зорчих явдал улам өргөжсөн байна. Өөрөөр хэлбэл "Хүйтэн дайн"-аас хойш хоёр улсын харилцаа бүх л төвшинд тоочвоос, улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, боловсрол, соёл урлаг, олон нийтийн байгууллагууд бизнесийн салбаруудад амжилттай хөгжиж байна.

### Дүгнэлт

Монгол улс нь өнгөрсөн түүхэндээ хил залгаа хоёр хөрштэйгөө харилцаагаа улам хөгжүүлэх ойртох бие биенээ харилцан хүндэтгэх, эрх тэгш харилцахад хэзээнээс нааш анхаарч ирснийг өнгөрсөн түүх харуулж байгаа бөгөөд эл харилцаа улам хөгжин бадарч байх Монгол улсын эрх ашигт нийцэж байгаа тул БНХАУ улс улам тогтвортой хөгжингүй улс болоход бүхий л талаар дэмжиж байдаг бөгөөд энэ ч Монгол улсын цаашдын хөгжилд ач тустай хэмээн ойлгож XXI зуунд хөл тавих гэж байна. Хоёр улсын нийгмийн байгуулал, үзэл суртал хэдийгээр сүүлийн 10 жилд бие биенээсээ ялгаатай хэдий ч цаашид харилцаа улам хөгжихөд алив нэгэн саад тотгор байхгүй хэмээн үзэж байна.

## Олон Улсын Харилцааны Дээд Сургууль

АЛТАН АРСАМЖ

# АЛТАН АРСАМЖ

VOL.3

1/2000

## "MONGOLIAN CULTURE, POLITICS AND MEDIA"

SFS/NUM

Dr. Bayasakh Kh.J.

It is my honour to present a paper on "Mongolian culture, politics and media" to the Fulbright Conference on American Media, Culture and Politics. I have chosen this topic with the purpose to introduce to our American Fulbrighters "Mongolian Culture, Politics and Media" in general while they are in Mongolia.

Actually it's very difficult to cover this topic by writing a few paper in a short time. However, I'll try to make it brief.

### Culture

Mongolia it is a country with a tremendous history and a unique culture. The Primitive Homo Sapiens inhabited in this heart of Asia 200-120 thousands years ago. Environment, namely climate, land formation, mineral resources, and native plants and animals all influence to create the culture. For example, most people in tropical regions wear draped clothing, which consists of one or more long pieces of cloth wrapped around the body. People who live in colder parts of the world wear tailored clothing, which is cut and sewn to fit the body. Mongolia is a country, which is located in colder part of the world. Its main economy is cattle breeding or animal husbandry and nomadic way of life designed the Mongolian clothing, having long saffan with overlapping to the right. That design was dictated by the need of nomadic life, where everybody was a horseman, herding their domestic animals or moving from one place to another on the horse back.